



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015.04.08 № 22/90

“БАТЛАН ХАМГААЛАХ АЖ
ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛ” ААТТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Албан шаардлага өгөх тухай

“Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ААТТӨҮГ-ын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус ААТТӨҮГ нь өөрийн эзэмшлийн Налайх дүүрэг дэх албан тушаалын 3 орон сууцыг Батлан хамгаалах яамны шийдвэрийн дагуу цэргийн албан хаагч С.Мандах, Г.Батсуурь, Г.Баттөр нарт гэрээгээр эзэмшүүлж суулгадаг боловч орон сууц эзэмшсэний хөлс төлүүлдэггүй байна.

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухай эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна”, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 17-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсийн төлбөрийг ТӨХ төвлөрүүлэн улсын төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Санхүү, эдийн засгийн яамны баталсан тухайн оны түрээсийн орлогын төлөвлөгөөтэй уялдуулан Төрийн өмчийн хороо тогтооно”, Төрийн өмчийн хорооны “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” 2007 оны 42 дугаар тогтоолын 2.в-д “төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлсэнээс олсон орлогын 20 хувийг Төрийн өмчийн хорооны төрийн сангийн дансанд сар бүр төвлөрүүлж улирал, жилийн эцэст Төрийн өмчийн хороотой тооцоо нийлж акт үйлдэж байх” гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47-р тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д ... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь :**

Албан тушаалын орон сууц эзэмшигч нартай байгуулсан “Орон сууц эзэмших гэрээнд “Батлан хамгаалахын сайдын 2005 оны 179 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалын орон сууцыг ашиглах журам”-ын 2.2-т заасан заалтыг тусган гэрээг

шинэчлэн байгуулж, 3-р сараас эхлэн орон сууц эзэмшигч нараас орон сууц эзэмшсэний хөлсийг төлүүлэх.

Биелэлтийг 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ААТТӨҮГ-ын захирал Б.Алтангэрэл, ерөнхий нягтлан бодогч Б.Нарангэрэл нарт даалгав.

АУДИТОР



Б.СЭРЖМЯДАГ